



**МОНГОЛ УЛСЫН
ДЭЭД ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 6/86

Улаанбаатар хот

Буцалтгүй тусламж олгох тухай

Шүүхийн захиргааны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь заалт, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын Дээд шүүхэд ажиллаж байсан Б.Санжмятав, Г.Бяраадамба нарын ар гэрээс ирүүлсэн хүсэлт, ар гэрийн гачигдалтай байдлыг харгалзан үзэж, тус бүр 200.000 /хоёр зуун мянган/ төгрөгийн буцалтгүй тусламж олгосугай.
2. Холбогдох хуульд заасны дагуу 400.000 /дөрвөн зуун мянган/ төгрөгт ногдох хувь хүний албан татвараас чөлөөлөгдөх болохыг дурьдсугай.
3. Буцалтгүй тусламжийн 400.000 /дөрвөн зуун мянган/ төгрөгийг төсвийн зохих зардлаас олгохыг Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн дарга Н.Булгамаад зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ж.НАРАНПҮРЭВ

050359